

Намтрын утга, бүтэц


Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Намтар гэдэг нь хүний төрсөн цагаас хойших амьдралын бүхий л түүхийг хэлнэ. Намтар нь товч, дэлгэрэнгүй 2 янз байна. Намтрыг он цагийн дарааллаар бичдэг.

Дасгал 14. Намтрын утга, бүтцийг тайлбарлаарай.

Галилейн намтар



Галилео Галилей 1564 онд Италийн Писад дээд зиндааны боловч ядуу, тоо хөгжим сонирхдог эцгийн гэр бүлд мэндэлжээ.

1581 оны нэгэн өглөө сүмд хүмүүс өвдөг сөхрөн мөргөл хийж байхад Галилей таазанд өлгөөтэй дэн савлахыг ажиглан ижил хугацаанд урагш хойш хөдөлж, дэнгийн хурд болон савлах зай нь багассаар байсныг анзаарчээ. 17 настай байсан тэрээр ажиглалтаасаа үүдэн туршилт хийсэн байна. Олсны үзүүрт ачаа зүүж, энгийн нэг дүүжин хийгээд олс ижил урттай байхад ачаа адил хугацаанд савладгийг тогтоож, олс урт байхад ачаа хол, богино байхад ойрхон савладаг гэдгийг олж мэджээ.



1609 -1610 онд гурав дахин өсгөдөг одон орны дуран авай бүтээж, сарны гадаргуу өө сэвгүй биш барзгар төдийгүй сар бөөрөнхий гэдгийг баталжээ.

Галилей 1637 онд хараагүй болсон ч 1642 оны 1-р сарын 8-нд нас барах хүртлээ ажилласаар байсан гэдэг.

Алхам 1. Дараах асуултад хариулж, намтрын утгыг ойлгоорой.

1. Хэний тухай намтар вэ?
2. Түүний эцгийн нэр хэн бэ?
3. Тэр хэдэн онд төрсөн бэ?
4. Тэр хаана төрсөн бэ?
5. Их эрдэмтэн болохын эхлэл түүх нь юу байв?
.....
6. Тэр дараа нь хэзээ, юуг бүтээсэн бэ?
.....
7. Тэр хэдэн онд нас барсан бэ?

Алхам 2. Дээрх намтарт өгүүлсэн түүхүүд нь бүтцийн аль хэсэгт хамаарах вэ? Зөв байрлуулж бичээрэй.

1. Галилей мэндэлжээ.

2. Галилей савлаж буй гэрлийг анзаарч, туршиж, мэдсэн.

3. Галилей дуран бүтээж, сарны шинжийг баталжээ.

4. Галилей хараагүй болсон хийгээд, нас барсан.

Эхлэл хэсэг

Гол хэсэг

Төгсгөл хэсэг

Алхам 4. Намтраас гол мэдээлэл, дэлгэрүүлсэн мэдээллийг ялгаж бичээрэй.

Гол мэдээлэл

Дэлгэрүүлсэн мэдээлэл

Галилей мэндэлжээ.

- 1564 онд
- Италийн Писад
- Ядуу гэр бүлд

Галилей анзаарчээ.

Галилей бүтээж, баталжээ

Дасгал 15. Намтрын хэл зүйн онцлогийг тайлбарлаарай.

Алхам 1. Дээрх намтрын өгүүлбэр бүрийг төгсгөсөн үйл үгийг түүж бичээд, нөхцөлийг тодруулж будаарай.

мэндэлжээ,

Алхам 2. Үйл явдлын дарааллыг хэлний ямар хэрэглүүрээр илэрхийлсэн байна вэ? Жишээ олж бичээрэй.

- Тооны нэрээр 1564 онд,
- Цагийн нэрээр
- Цагийн утгатай өгүүлбэрээр

Алхам 3. Дээрх намтар нь хүүрнэмж хэв маягаар бичигдсэн болохыг 2 жишээгээр батлаарай.

Хүүрнэмж эхийн үндсэн шинж	Батлах жишээ
Үйл явдал нь цагийн дарааллаар өрнөдөг.	1. 2.
Өгүүлбэрүүд нь цагаар төгсгөх нөхцөлөөр хувилдаг.	1. 2.

Дууссан:онсарөдөр